



ХӨЛ ХОРИОНЫ ҮЕ ДЭХ АМЬД ЯВАХ, ЭРҮҮЛ МЭНДЭЭ ХАМГААЛУУЛАХ ЭРХ

Коронавируст халдварын цар тахлыг дэлхий нийтээрээ даван туулж буй энэ цаг үед Монгол Улс ч мөн хүнд сорилттой өдөр тутам тулгарч байна. Энэ цаг үед үүсээд буй нөхцөл байдалд хөндлөнгийн байр сууринаас дүн шинжилгээ хийж, хүндрэл бэрхшээлийг хохирол багатай даван туулахад хувь нэмэр болох гарц шийдэл санал болгох ажлыг эхлүүлээд байгаа билээ. Халдварт өвчний дэгдэлтээс сэргийлэх аливаа шийдвэр, үйл ажиллагаа хугацаа

алдахгүй гарч байж үүдэн гарах хор хохирлыг бууруулах талтай ч энэ мэт богино шинжилгээнүүд тэдгээр шийдвэрийн чанар, үр нөлөөг дээшлүүлэхэд тустай хэмээн үзлээ. Энэ удаагийн дугаарт цар тахалтай тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлж буй хөл хорионы улмаас иргэдийн бусад эрх, эрх чөлөө зөрчигдөж, эсхүл зөрчигдөж болзошгүй байгааг анхааруулахыг зорилгоо.

НЭГ. ТУЛГАМДСАН АСУУДАЛ

Улаанбаатар хот эмнэлгийн хүртээмж, техник, тоног төхөөрөмж сайтайн улмаас орон нутгийн иргэд нийслэлд ирж эмнэлгийн тусламж авах шаардлага үүсдэг. Харамсалтай нь Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед иргэн Н эмнэлгийн тусламж яаралтай авч чадаагүйн улмаас 22-ын товчоон дээр амь насаа алдлаа.¹

Зарим иргэд² хатуу хөл хорионд орсны улмаас эрүүл мэндээ хамгаалуулах, эм, эмнэлгийн тусламж авах эрх нь зөрчигджээ. Тухайлбал, иргэн З-ийн хөхний судас бугалж 9 хоносон тул 2020 оны 12 дугаар сарын 3-ны өдөр эмнэлгийн тусламж авахаар 103 болон өрхийн эмнэлэгтээ хандахад халдвар гарсан байрны оршин суугч тул нэвтрэх боломжгүй, 119-д хандаж зөвшөөрөл ав гэсэн хариуг өгчээ.³ Энэ нь хүндэрвэл мэс засал хийхэд хүргэдэг өвчин тул

яаралтай эмнэлгийн тусламж зайлшгүй шаарддаг.

Эм, эмнэлгийн бүтээгдэхүүнийг QR кодтой автомашинаар тодорхой цагт хүргэхээр зохицуулсан. Эм, эмнэлгийн бүтээгдэхүүний хүргэлт нь хүнсний бүтээгдэхүүнийхтэй адил биш бөгөөд хүний амь нас, эрүүл мэндээ хамгаалуулах, эм, эмнэлгийн тусламжийг яаралтай авах шаардлагаас үүдэлтэйгээр цагаар хязгаарлах боломжгүй юм. Эм, эмнэлгийн бүтээгдэхүүн нийлүүлэгч компаниуд энэ үндэслэлээ хэлж тайлбарласан ч замын хөдөлгөөн, төлөвлөлт, зохицуулалт, инженерчлэлийн газраас “Бүтэн өдөржингөө эм, эмнэлгийн бүтээгдэхүүн тараах боломжгүй буюу тараах нөхцөл үүсэхгүй” гэсэн хариу өгсөн⁴ байна.

2020 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр бөөрний дутагдалтай иргэнийг диализын аппаратад

¹ <https://news.mn/r/2380783/>; urug.mn

² Баянзүрх дүүргийн 41-р байрнаас коронавируст халдвар илэрсний улмаас тус байрны иргэдийн хөдөлгөөнийг 14 хоногийн хугацаанд бүрэн хязгаарласан.

³ Иргэн З-ийн өгсөн ярилцлага <https://livetv.mn/>

⁴ Замын хөдөлгөөн, төлөвлөлт, зохицуулалт, инженерчлэлийн газар өөрийн фэйсбүүк хаягаараа хүсэлт гаргасан аж ахуй нэгжүүдэд хариу өгсөн. 2020 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр.

оруулахаар эмнэлэг рүү нь хүргэх замд QR кодгүй тул 17:00 цагаас хойш явахыг шаардаж, явуулаагүй байна.⁵ Гэтэл диализын аппаратад орох шаардлагатай нийслэлийн 650, орон нутгийн 350, химийн эмчилгээ хийлгэх шаардлагатай нийслэлийн

700 гаруй, орон нутгийн 200 гаруй иргэн байгаа бол жирэмсний хяналтад 3650 эмэгтэй байна.⁶ Тиймээс дээрх шаардлагын улмаас эдгээр иргэдийн амьд явах, эрүүл мэндээ хамгаалуулах эрх хөндөгдөж болзошгүй юм.

ХОЁР. АСУУДАЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

2.1. Хөл хорио тогтоосонтой холбоотойгоор иргэдийн зорчих эрх хязгаарлагдаж, үүнийг дагаад бусад эрх, эрх чөлөө хязгаарлагдах нөхцөл үүсдэг. Коронавируст халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3-т “Цар тахлаас урьдчилан сэргийлэх, нийгмийн эрүүл мэндийг хамгаалах зорилгоор гарах шийдвэр, арга хэмжээ нь иргэний үндсэн эрх, эрх чөлөөг хамгийн бага хязгаарласан, бодитой, тохирсон байна” хэмээн заасан. Эрүүл мэндээ хамгаалуулах эрх нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.13, Монгол Улсын 1974 онд соёрхон баталсан Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын Пактын 12 дугаар зүйлд тус тус баталгаажсан. Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хорооны Ерөнхий зөвлөмж 14-т энэ эрхийг дэлгэрүүлэн тайлбарласан бөгөөд энэ эрхэд тавих хязгаарлалтыг ч мөн зааж өгсөн.⁷ Гэтэл дээр дурдсан тохиолдлууд нь эрхийн хязгаарлалтад тавих шаардлагад нийцэхгүй байгаа тул иргэдийн эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж үйлчилгээ авах эрхийг зөрчиж байна гэж үзэхээр байна. Учир нь хүн өөрийн хамгийн эрхэм зүйл болох амь нас, эрүүл мэндээ хамгаалуулах, стандартад нийцсэн эм, эмнэлгийн тусламж үйлчилгээг авах эрхтэй.⁸ Нэг талаас, нийтийн эрүүл мэндийг хамгаалах зорилгоор хөл хорио тогтоож байгаа ч нөгөө талаас, хэрвээ иргэний амь насанд аюул, эрсдэл тохиолдсон бол яаралтай тусламжийг цаг алдалгүй үзүүлж амь насыг аврах учиртай.

Өөрөөр хэлбэл, явцуу утгаар амьд явах эрхийн тухай үзэл баримтлалд цаазаар авах, үр хөндөх асуудлыг чухалчлан авч үздэг ч өргөн утгаар амьд явах эрх нь эрүүл мэндээ хамгаалуулах эрхийн агуулгаар ч хамгаалагддаг.

2.2. Улсын Онцгой комиссын 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 33 дугаар хурлын тэмдэглэлийн 3.1-т “Улсын онцгой комиссын 2020 оны 11 дүгээр сарын Дугаар 12 тогтоол гарсантай холбогдуулан хот, аймаг, нийслэл, сум, дүүрэг хоорондын хүнсний болон бусад ачаа тээвэрлэлтийг хэвийн явуулах, хүндэтгэн үзэх шалтгааны улмаас (ажлын зайлшгүй шаардлага, хойшлуулшгүй ажил, албан томилот, эмнэлгийн яаралтай тусламж, үйлчилгээ, ар гэрийн гачигдал гэх мэт) хот хооронд зорчих төрийн албан хаагч, иргэдийн нотлох баримтыг үндэслэн хүндрэл чирэгдэл учруулахгүйгээр хяналтын цэгээр шалган нэвтрүүлэх арга хэмжээг тухай бүр авч ажиллахыг⁹ Нийслэлийн онцгой комиссын даргад үүрэг болгожээ. Дээрх үүрэг болгосон тэмдэглэлээс харахад зайлшгүй шаардлагаар Улаанбаатар хотод нэвтрэх шаардлага бүхий иргэд, тус нөхцөлөө нотлох баримтаар баталгаажуулах шаардлагатай бөгөөд үүнд эмчийн бичиг, эрүүл мэндийн байгууллагын үзлэгийн хуудас хамаарах юм. Гэтэл нэн яаралтай эмнэлгийн тусламж авах шаардлага үүссэн тохиолдолд нотлох баримт шаардах нь зүй ёсны шаардлага биш. Нөгөө талаас, хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргаж байгаа бол Захиргааны ерөнхий хуулийн 70 дугаар зүйлд заасан тусгай зохицуулалтыг баримтлах

⁵ Энэхүү зөрчлийг баталгаажуулах үүднээс шаардлага тавьсан иргэнтэй нь холбогдсон.

⁶ Улсын онцгой комиссын 2020 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн мэдээлэл.

⁷ CESCR General Comment No14: The Right to the Highest Attainable Standard of Health (Art 12), August 2000, <https://www.refworld.org/pdfid/4538838d0.pdf>, para 28, 29

⁸ CESCR (Committee on Economic, Social, and Cultural Rights). 2000.). 11 August. Doc. E/C.12/2000/4. <http://docstore.ohchr.org/SelfServices/FilesHandler.ashx?enc=4slQ6QSmIBEDzFEovLCuW1AVC1NkPsgUedPIF1vfPMJ2c7ey6PAz2qaojTzDJmCOy%2B9t%2BsAtGDNzdEqA6SuP2r0w%2F6sVBGTpvTSCbiOr4XVFTqhQY65auTFbQRPWNdxL> para 1

⁹ Улсын онцгой комиссын 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 33 дугаар хурлын тэмдэглэл.

шаардлагатай. Тухайлбал, хэм хэмжээ тогтоосон актыг батлах, тус баталсан актаа олон нийтэд мэдэгдэх шаардлагатай. Иймээс хөл хорио тогтоож буй нөхцөлд хэний ч амь нас эрсдэх боломжтой тул шуурхай, түргэн тусламж үзүүлэх нөхцөлийг урьдчилан бүрдүүлсэн байх ёстой. Өөрөөр хэлбэл, орон нутгийн иргэн нийслэлд нэвтрэхдээ Ковид-19 цар тахлын шинжилгээ өгсөн байх ёстой бөгөөд шинжилгээний хариу 48 цагийн дотор гардаг. Энэ хугацаанд иргэдийн амь нас, эрүүл мэндэд аюул, эрсдэл учирсан тохиолдолд шуурхай шийдэх зохицуулалтыг төлөвлөсөн байх ёстой.

1.3. Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээ, Гамшгаас хамгаалах хууль болон дээр дурдсан хуулиудад заасан хөндөж үл болох туйлын эрхүүд бий. Тухайлбал, Монгол Улсын Үндсэн хуулийн 19-р зүйлийн 2 дахь хэсэгт “..Хязгаарласан хууль нь хүний амьд явах эрх, итгэл үнэмшилтэй байх, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө, түүнчлэн хэнд боловч эрүү шүүлт тулгах, хүнлэг бус хэрцгий хандахыг хориглосон хуулийн заалтыг үл хөндөнө” гэж заажээ. Гэтэл Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед эрүүл мэндийн тусламж авч чадаагүйн улмаас

хүний амь нас эрсдсэн тохиолдлууд гарсан нь ямар ч тохиолдолд хөндөж үл болох амьд явах эрх зөрчигдсөн гэж үзэхээр байна. Монгол Улс 1974 онд соёрхон баталсан Иргэний болон улс төрийн эрхийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Хүн бүр амьд явах салшгүй эрхтэй. Энэ эрхийг хуулиар хамгаална. Хэний ч амь насыг дур мэдэн бусниулж болохгүй” хэмээн заасан. Тус зүйлийг НҮБ-ын Хүний эрхийн хороо 36 дугаар Ерөнхий зөвлөмжөөр тайлбарласан.¹⁰ Тиймээс халдвар хамгааллын зохицуулалт, зохион байгуулалтын алдааны улмаас хүний амь нас эрсдсэн нь амьд явах эрхийг хуулиар хамгаалах үүргээ төр биелүүлээгүйн улмаас энэ эрх зөрчигдсөн гэж үзэхээр байна. Учир нь тус зөвлөмжид зааснаар халдвар хамгааллын зохион байгуулалт, зохицуулалтын алдаа нь түргэн тусламжийн үйлчилгээнд саад учруулж байгаа тул (түргэн тусламжийн ажилтнууд хөл хорионд байгаа иргэний гэрт нэвтрэх, хөл хорионд буй иргэн түргэн тусламжийн үйлчилгээ авахаар явах) энэ нь хүний амьд явах эрхийг хамгаалах хангалттай нөхцөлийг бүрдүүлээгүй гэсэн нөхцөлд хамаарч байна.¹¹

ГУРАВ. САНАЛ, ЗӨВЛӨМЖ



- Эмнэлгийн тусламж зайлшгүй авах шаардлагатай иргэдийг бүртгэлжүүлж, QR код гаргаж өгөх;
- Нэн яаралтай эмнэлгийн тусламж авах шаардлагатай иргэн замын хөдөлгөөнд цагийн хязгаарлалтгүй оролцох зохицуулалтыг нэг мөр хэрэгжүүлэх;
- Хатуу хөл хорионд орсон иргэнд эмнэлгийн тусламж яаралтай үзүүлэх журмыг гаргаж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ шуурхай үзүүлэх нөхцөлөөр хангах;
- Хот хооронд нэвтрэх цэгүүдэд эмнэлгийн тусламж яаралтай авах шаардлагатай, амь нас

эрсдэж болзошгүй тохиолдлыг зөвшөөрөл болон бусад нотлох баримт шаардалгүй нэвтрүүлж, коронавируст халдварын сэжиг бүхий тохиолдол хэмээн үзэж халдвар хамгааллын дэглэм сахисан цэгт яаралтай тусламж үзүүлэх боломжийг бий болгох;

- Хатуу хөл хорионы дэглэм тогтоосон үед эм, эмнэлгийн бүтээгдэхүүн нийлүүлэх компаниудад цагийн хязгаарлалтгүй тээврийн хөдөлгөөнд оролцох боломж олгох.

¹⁰ General Comment No36: Article 6 (Right to Life), UN Human Rights Committee, Sep 2019, https://tbinternet.ohchr.org/_layouts/15/treatybodyexternal/Download.aspx?symbolno=CCPR%2fC%2fGC%2f36&Lang=en

¹¹ General Comment No36: Article 6 (Right to Life), UN Human Rights Committee, Sep 2019, https://tbinternet.ohchr.org/_layouts/15/treatybodyexternal/Download.aspx?symbolno=CCPR%2fC%2fGC%2f36&Lang=en

